



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 69.

Есөнбулаг сум

**Хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх ” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөв, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган батлуулж, биелэлтийн явцыг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА



Т.ГАНЗОРИГ

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл ба шаардлага

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, хөгжилд чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэн, үр ашгийг нь нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээнд далд эдийн засгийг бууруулан, татварын бааз суурийг өргөжүүлэх чиглэлээр мөрдөгдөж буй хууль, засгийн газрын тогтоол, журмыг хэрэгжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлэх нь уг хөтөлбөрийн үндэслэл шаардлага болно.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, татварын бааз суурийг нэмэгдүүлэх, татварын үйлчилгээг сайжруулах, татвар, төлбөр, хураамж хураах эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудын ажлын уялдааг дээшлүүлэх, дотоод нөөц боломжийг бүрэн ашиглахад хөтөлбөрийн зорилго оршино.

### Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Татварын бүх төрлийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж, хэрэглэгчийн үйлчилгээний менежментэд тулгуурлан татвар төлөгчдийг төлөвшүүлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэн, татвар төлөгч өөрөө татвараа үнэн зөв тодорхойлон, сайн дурын үндсэн дээр татвараа бүрэн төлдөг арга механизмыг улам боловсронгуй болгоно.

3.2. Далд эдийн засгийг ил болгон татварын бааз суурийг өргөжүүлж, далд эдийн засгийн хор хохирлыг нийтэд таниулах ажлыг оновчтой зохион байгуулан, татвар төлөх нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлж, нийгмийн сэтгэл зүйг гэмтээхгүй ажиллана.

3.3. Төсвийн орлогын төлөвлөгөөг бодит байдалд зөв тооцоололд суурилан тогтооно.

3.4. Татвар, төлбөр, хураамжийг хураах эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд болон татвар, төлбөр, хураамжийг хураахад хамтран ажилладаг байгууллагуудын ажлын уялдааг дээшлүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн хөшүүрэг бий болгоно.

### Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. 1 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

4.1.1. Татвар төлөгчдийн эрсдэлийг тооцон, ангилал тус бүрт зориулагдсан сургалт, үйлчилгээг хүргэнэ.

4.1.2. Сургалт, сурталчилгааны ажлыг тогтмолжуулна.

4.1.3. Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулж, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэн, татварын үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлнэ.

4.2. 2 дугаар зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

4.2.1. Нуугдмал орлогыг ил болгох, татварын бааз суурийг өргөжүүлэх зорилгоор ихээхэн хэмжээний орлого бүхий иргэд, аж ахуйн нэгжүүдэд татварын ерөнхий хуулийн дагуу тооллого, үзлэг хийж, татварын ногдуулалтыг нэмэгдүүлнэ.

4.2.2. Эрсдэлийн удирдлагыг нэвтрүүлж, татварын хууль, тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулна.

4.2.3. Хувь хүн, хуулийн этгээд далд эдийн засагтай байх сонирхол, хандлагыг бууруулж, татвар төлөгчдийг татварын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

4.2.4 Хөрөнгийн болон үйл ажиллагааны татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлж, бүртгэлжүүлэн татварт бүрэн хамруулна.

4.3. 3 дугаар зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

4.3.1. Төсвийн төслийг олон жилийн динамик судалгаа, холбогдох мэдээлэлд үндэслэн, орлогод нөлөөлөх хүчин зүйлсийг тооцож үндэслэлтэй боловсруулна.

4.3.2. Төсвийн орлого бүрдэлтэд хяналт тавьж, төсвийн орлого төлөвлөлтөд нөлөөлөх хүчин зүйлийн талаарх мэдээллийн баазыг төсвийн орлогын нэр төрлөөр, татвар төлөгч байгууллагаар, татвар ногдох зүйлээр тус тус бэлтгэн боловсруулж, мэдээллийн баазыг тухай бүр шинэчилнэ.

4.4. 4 дүгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дараах төрийн байгууллагуудтай хамтран ажиллана.

4.4.1. Улсын бүртгэлийн хэлтэс хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд тэмдэгтийн хураамж болон хөрөнгө борлуулсны орлогын албан татварыг тухай бүр төсөвт төвлөрүүлэн, үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн хөдөлгөөний мэдээг улирал бүр Татварын хэлтэст хүргүүлнэ.

4.4.2. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтийг бүрэн хариуцан, газар эзэмшигч болон өмчлөгчдийн хөдөлгөөний мэдээг Татварын хэлтэст хүргүүлэн хамтран ажиллана.

4.4.3. Байгаль орчин, аялал жуулчлалын газар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчдийн бүртгэлийг гарган, байгалийн нөөц ашиглах дүгнэлт, зөвшөөрөл авсан иргэн, аж ахуйн нэгжийн мэдээллийг тухай бүр Татварын хэлтэст хүргүүлэн үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийж, төлбөрийг бүрэн барагдуулахад Татварын хэлтэс болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана.

4.4.4. Цагдаагийн газар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд галт зэвсгийн бүртгэлийн баазыг шинэчлэн, шилжилт хөдөлгөөний мэдээг Татварын хэлтэст хүргүүлэн, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр төлөөгүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байхад хамтарч ажиллана.

4.4.5. Аймгийн Автотээврийн төв хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох татвар, төлбөрийг төлсөн тээврийн хэрэгслийг үзлэг, оношлогоонд хамруулан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөний мэдээг Татварын хэлтэст хүргүүлэн, гадны дугаартай тээврийн хэрэгслийг орон нутгийн дугаартай болгоход хамтран ажиллана.

4.4.6. Мэргэжлийн хяналтын газар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр төлөгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.



4.4.7. Орон нутгийн өмчийн газар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд орон нутгийн өмчид бүртгэлтэй хувьчлах болон түрээслэх хөрөнгийн судалгааг гарган, холбогдох орлогыг бүрэн төвлөрүүлэх ажлыг хариуцан зохион байгуулна.

4.4.8. Сумдын Засаг дарга нар хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сумын болон аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлж, орлогын эх үүсвэрийг бүрэн дайчлах чиглэлээр боломжит бүх арга хэмжээг авч ажиллана.

4.4.9. Дээрх байгууллагуудтай хамтран ажиллах сонирхлыг бий болгоход чиглэгдсэн эдийн засгийн хөшүүрэг болох урамшуулал, болзол, уралдааныг зарлан идэвхжүүлнэ.

4.4.10. Мөрдөгдөж буй татварын хууль болон холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэх санал хүсэлтийг авч нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1.1. Улсын төсөв

5.1.2. Орон нутгийн төсөв

5.1.3. Олон улсын байгууллага, хандивлагчийн тусламж, дэмжлэг болон төслийн санхүүжилт

5.2. Аймгийн Засаг дарга нь орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нөхцөлд төлөвлөгөөнөөс давсан орлогын дүнгээс хамааруулан 10 хүртэл хувиар тооцож хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг аймгийн Татварын хэлтэс нэгдсэн удирдлагаар хангаж, татвар, төлбөр, хураамж хураах эрх бүхий байгууллага болон тэдгээрийн ажилтан, албан хаагчдын хамтын оролцоогоор хэрэгжүүлнэ.

6.2. Татвар, төлбөр, хураамж хураах эрх бүхий байгууллагууд өөрсдийн хариуцсан чиглэлээр хөтөлбөрт тусгасан зорилтуудыг тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг хагас жилээр /тухайн жилийн 7 дугаар сарын 5-ны дотор/, бүтэн жилээр /тухайн жилийн дараа оны 1 дүгээр сарын 5-ны дотор/ аймгийн Татварын хэлтэст хүргүүлнэ.

6.3. Татварын хэлтэс нь байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэж, биелэлтийг хагас жилээр /тухайн жилийн 7 дугаар сарын 10-ны дотор/, бүтэн жилээр /тухайн жилийн дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор/ гаргаж аймгийн Засаг дарга, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулна.

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг сум, байгууллагын дарга нар хариуцан зохион байгуулах бөгөөд хэрэгжилтийг хангаагүй дарга нарт хариуцлага тооцон ажиллана.

Долоо. Хөтөлбөрийн хугацаа

7.1. Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт, үр дүнг үнэлэх

8.1. Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн үр дүн нь аймаг, орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт /нэр төрлөөр/, татварын бааз суурь, татварт хамрагдалтын түвшин нэмэгдсэн байдлаар хэмжигдэнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр тооцно.

8.2.1. Орлогын төлөвлөгөөний биелэлт / хувиар/

а/. Аймгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт

б/. Сумын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт

8.2.2. Татварт хамрагдалт /татвар төлөгчийн тоо, хамрагдалтын хувь/

а/. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар

б/. Галт зэвсгийн албан татвар

в/. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

г/. Үйл ажиллагааны орлогын албан татвар

8.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

Үзүүлэлтүүд	2017	2018	2019	2020
1. Орлогын төлөвлөгөөний биелэлт				
1.1. Гүйцэтгэл өмнөх оноос нэмэгдэх	1.0%	1.0%	1.0%	1.0%
1.2. Биелэлт /хувиар/	100.0%	100.0%	100.0%	100.0%
2. Татварт хамрагдалт				
2.1. Татвар төлөгчийн тоо өмнөх оноос нэмэгдэх	3.0%	3.0%	3.0%	3.0%
2.2. Хамрагдалт /хувиар/	90.0%	90.5%	91.0%	91.5%

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НАРИЙВЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт		Санхүүжилт		Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
		Хэмжих нэгж	Хүрэх үр дүн	Эх үүсвэр	Төсөв /сая.төг/		
<p>Нэг. Татварын бүх төрлийн үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж, хэрэглэгчийн үйлчилгээний менежментэд тулгуурлан татвар төлөгчдийг төлөвшүүлэх, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэн, татвар төлөгч өөрөө татвараа үнэн зөв тодорхойлон, сайн дурын үндсэн дээр татвараа бүрэн төлдөг арга механизмыг улам боловсронгуй болгоно.</p>							
1	Татвар төлөгчийн татварын хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу эрсдэл тооцож, дүн шинжилгээ хийнэ.	Эрсдэлийн түвшин	Эрсдэлийг бага буюу зөвшөөрч болохуйц түвшинд хүргэнэ.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс
2	Татвар төлөгчдийн эрсдэлээр тооцогдсон ангилал тус бүрт зориулагдсан сургалт, үйлчилгээг хүргэнэ.	Хамрагдалт	Татвар төлөгчдийн 60-аас доошгүй хувийг хамруулна.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс
3	Татвар төлөгчийн сегмент тус бүрээр эрсдэл тооцож, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлнэ.	Сегментийн ангиллаар хамрагдсан татвар төлөгчид	Татварын хяналт шалгалыг эрсдэлд суурилсан байдлаар, хуулийн хүрээнд чирэгдэл, дарамтгүй хийгдэх нөхцөл бүрдэж зөрчил буурсан байна.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч нартай хамтран шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн татварын өрийг хураан барагдуулах ажлыг зохион байгуулна.	Өр барагдуулалт	Гүйцэтгэлийн стандарт хангагдана.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс

180.

5	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй татвар төлөгчдөд хуулийн хүрээнд хариуцлага тооцно.	Хэрэг-жүүлээгүй татвар төлөгчдийн тоо	Хуулийн хэрэгжилт хангагдана.	-	-	Тухай бүр	Татварын хэлтэс
6	Татвар төлөгч болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах харилцааг өргөжүүлнэ.	Үнэлгээ хийлгэсэн байдал	Татварын байгууллага, татварын байцаагчийн үйл ажиллагааны талаар иргэд үнэн зөв ойлголттой болсон байна.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс, ТББ
7	Шинэчлэгдсэн хуулиудын талаарх сургалтыг сумдад зохион байгуулна.	Хамрагдалт	18 сумыг бүрэн хамруулсан байна.	-	-	2019-2020 онд	Татварын хэлтэс
8	Татвар, төлбөр, хураамж хураах эрх бүхий албан тушаалтнуудын нэгдсэн сургалтыг зохион байгуулж, үр дүнг тооцож хэвшүүлнэ.	-	Төрийн байгууллага, албан тушаалтнуудын ажлын уялдаа холбоо, хариуцлага сайжирна.	-	-	Жил бүр	СТСХ, Татварын хэлтэс
9	Цахим хуудсанд татвар төлөгчдийн хэлэлцүүлэг үүсгэн, санал асуулгын булан ажиллуулна.	Хандалт	Татвар төлөгчдийн 50 хүртэлх хувийг хамруулна.	-	-	2017 оноос	Татварын хэлтэс
10	Татварын тайлан өгөх, лавлагаа, тодорхойлолт авах, татвар төлөгчөөр бүртгүүлэх зэрэг үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломжийг бүрдүүлнэ.	Цахим татварын системээр үйлчлүүлсэн татвар төлөгчдийн тоо	Лавлагаа, тодорхойлол-тын 80-аас доошгүй хувийг цахимаар авдаг болно.	-	-	2017 оноос	Татварын хэлтэс
11	Татварын төлбөр тооцоог смарт банк, мобайл банк, интернет болон пос машинаар гүйцэтгэдэг тогтолцоог нэвтрүүлнэ.	Цахим интернет төлөлтийн тоо	Татварын төлөгчдийн цаг хугацааг хэмнэсэн, үйлчилгээ чирэгдэлгүй хурдан шуурхай байдал хангагдсан байна.	-	-	2017 оноос	Татварын хэлтэс
12	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу урамшуулал олгох ажлыг хэрэгжүүлэн, татвар төлөгчдийг Монгол Улсын стандартын шаардлага хангасан	Төлбөрийн баримт өгөх татвар төлөгчийн тоо	Суутган татвар төлөгчийг 100 хувь, суутган бус татвар төлөгчийн 50-аас доошгүй хувь нь төлбөрийн баримт өгч хэвшсэн байна.	-	-	2017 оноос	Татварын хэлтэс

	кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэж, худалдан авагчдад төлбөрийн баримт өгч хэвшүүлнэ.						
<p>Хоёр. Далд эдийн засгийг ил болгон татварын бааз суурийг өргөжүүлж, далд эдийн засгийн хор хохирлыг нийтэд таниулах ажлыг оновчтой зохион байгуулан, татвар төлөх нийгмийн сэтгэлгээг төлөвшүүлж, нийгмийн сэтгэл зүйг гэмтээхгүй ажиллана.</p>							
1	Иргэн, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын улирал, жилийн тайлангаар гарсан татварын ногдлыг явуулж буй үйлдвэрлэл, үйлчилгээний цар хүрээ борлуулалтын орлогын хэмжээтэй уялдаж бодитой байгаа эсэхэд хяналт тавьж, ажлын зураг авалт хийх ажлыг зохион байгуулна.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Татварын ногдлыг тайланд бүрэн тусгаж, татварын тайлангаар гарч байгаа татварын ногдол үнэн зөв болно.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс
2	Ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдийн борлуулалтын орлого, татвар ногдох орлогоос хасагдах зардал, ногдуулсан татварын хэмжээг жишиж татварыг төлүүлж хэвшүүлнэ.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ.	-	-	2017 оноос	Татварын хэлтэс
3	Татвар төлөгчийн ирүүлсэн тайланд ногдуулалтын хяналт хийж, татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах.	Тайлан засах хүсэлт ирүүлсэн татвар төлөгчийн тоо	Татвар төлөгчдийг эрсдэлээс хамгаалж татварын албанд хандах илтгэл нэмэгдсэн байна.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс
4	Уул, уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй гадны татвар төлөгчдийг татварт бүрэн хамруулна.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Холбогдох орлогыг бүрэн төвлөрүүлсэн байна.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс
5	Хөрөнгийн болон үйл ажиллагааны татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлж, бүртгэлжүүлэн татварт бүрэн хамруулна.	Татвар төлөгчийн тоо, хамрагдалт	Татвар төлөгчдийн тоо жил бүр өмнөх оны хүрсэн түвшингээс 3 хувиар нэмэгдэж, 90-өөс доошгүй хувь нь хамрагдсан байна.	-	-	Жил бүр	Татварын хэлтэс

7088



Гурав. Төсвийн орлогын төлөвлөгөөг бодит байдалд зөв тооцоололд суурилан тогтооно.

1	Орлого төвлөрүүлэгч байгууллагууд өөрсдийн хариуцсан чиглэлээр орлогын гүйцэтгэлийн сүүлийн жилүүдийн мэдээллийн баазыг үүсгэн, өөрчлөлтийг тухай бүр хийнэ.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөлт сайжирч, орлогын төрөл тус бүрээр биелэлт бүрэн хангагдсан байна.	-	-	2017 онд	ТХ, БОАЖГ, ГХБХБГ, ОНӨГ, УБХ
2	Төсвийн орлогын төслийг холбогдох маягтын дагуу мэдээллийн бүрэн, үнэн зөв байдлыг ханган боловсруулж, цаг хугацаанд нь нэгтгүүлж хэвшүүлнэ.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Төлөвлөлт сайжирч, орлогын төрөл тус бүрээр биелэлт бүрэн хангагдсан байна.	-	-	Жил бүр	ТХ, БОАЖГ, ГХБХБГ, ОНӨГ, УБХ, Сумын Засаг дарга нар
3	Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний хуваарийг тухайн орлогын онцлог, хуульд заасан хугацаатай уялдуулан үндэслэлтэй боловсруулж, хэрэгжилтийг бүрэн хангуулна.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	9-өөс доошгүй сараар орлогын нэр төрөл бүрээр төлөвлөгөөг биелүүлсэн байна.	-	-	Тухай бүр	Аймгийн Засаг дарга, Сумын Засаг дарга нар, ТХ
4	Бүртгэл, мэдээллийн сангийн үнэн зөв, бодит байдлыг хангуулах, ашиглалт, баяжуулалтад хяналт тавих, мэдээ, нэгтгэлийг цаг хугацаанд нь хянан, мэдээллийн сангийн үзүүлэлтүүдээр баяжуулан, тогтоосон цаг хугацаанд үнэн зөв мэдээллээр удирдлага, холбогдох зохион байгуулалтын нэгжийг хангана.	-	Удирдлагууд үнэн зөв бодит мэдээллээр хангагдсан байна.	-	-	Сар бүр	Татварын хэлтэс
Дөрөв. Татвар, төлбөр, хураамжийг хураах эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд болон татвар, төлбөр, хураамжийг хураахад хамтран ажилладаг байгууллагуудын ажлын уялдааг дээшлүүлэхэд чиглэгдсэн эдийн засгийн хөшүүрэг бий болгоно.							
1	Үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны албан татварыг худалдан борлуулсан иргэн, хуулийн этгээд төсвийн орлогод төвлөрүүлсэн тохиолдолд тухайн хөрөнгийг шилжүүлнэ.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Татвар төлөгчдийг татварт бүрэн хамруулна.	-	-	Тухай бүр	УБХ

2083

2	Үл хөдлөх хөрөнгө эзэмшигчдийн хөдөлгөөний мэдээг Татварын хэлтэст хүргүүлнэ.	Хамрагдалт	Мэдээллийн баазын үнэн зөв байдал хангагдаж татварт бүрэн хамруулна.	-	-	Улирал бүр	УБХ
3	Иргэдийн шилжилт хөдөлгөөн хийхдээ багийн Засаг дарга нараас гаргасан "Тойрох хуудас"-ыг үндэслэн шилжүүлж, төрийн байгууллагуудтай тооцоо нийлдэг болгоно.	-	Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлнэ.	-	-	2017 оноос	УБХ, Сумын Засаг дарга нар
4	Бэлчээрийн болон зам, шугам сүлжээний газрын төлбөрийн ногдуулалтыг хийх, хуульд заасан хугацааны дотор төсөвт төвлөрүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулна.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Ногдуулалтыг бүрэн хийж орлогыг бүрэн төвлөрүүлнэ.	-	-	2017 онд	ГХБХБГ
5	Газар эзэмшигч болон өмчлөгчдийн бүртгэл мэдээг Татварын хэлтэст хүргүүлнэ.	Хамрагдалт	Мэдээллийн баазын үнэн зөв байдал хангагдаж татварт бүрэн хамруулна.	-	-	Улирал бүр	ГХБХБГ
6	Байгалийн болон ашигт малтмалын нөөц ашиглагчдын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.	Хамрагдалт	Татвар төлөгчдийг бүрэн хамруулж орлогыг бүрэн төвлөрүүлнэ.	-	-	Жил бүр	БОАЖГ, МХГ, Татварын хэлтэс
7	Ус ашиглах дүгнэлт авсан аж ахуйн нэгж байгууллагын мэдээллийг Татварын хэлтэст хүргүүлнэ.	Хамрагдалт	Ус ашиглагчдыг татварт бүрэн хамруулна.	-	-	Тухай бүр	БОАЖГ
8	Тухайн ондоо төлбөр, хураамжаа төлөөгүй татвар төлөгчдийн судалгааг гарган татварын хяналт шалгалтад хамруулан алданги, торгууль тооцож өрийг барагдуулна.	Өр барагдуулалт	Орлогыг бүрэн төвлөрүүлж, өрийг стандарт ханган барагдуулна.	-	-	Жил бүр	ГХБХБГ, БОАЖГ, Татварын хэлтэс
9	Галт зэвсгийн бүртгэлийг шинэчлэн, бааз суурийг бодитой болгоно.	Хамрагдалт	Мэдээллийн баазын үнэн зөв байдал хангагдаж татварт бүрэн хамруулна.	Орон нутгийн төсөв	10.0	2018 онд	Цагдаагийн газар, Сумын ЗДТГ, ТХ
10	Галт зэвсэг эзэмшигчдийн хөдөлгөөний мэдээг Татварын хэлтэст хүргүүлнэ.	Хамрагдалт	Мэдээллийн баазын үнэн зөв байдал хангагдаж татварт бүрэн хамруулна.	-	-	Улирал бүр	Цагдаагийн Газар
11	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний мэдээг Татварын хэлтэст хүргүүлнэ.	Хамрагдалт	Мэдээллийн баазын үнэн зөв байдал хангагдаж татварт бүрэн хамруулна.	-	-	Улирал бүр	Автотээврийн төв

12	Гадны дугаартай тээврийн хэрэгслийг аймгийн бүртгэл, дугаартай болгож албан татварыг орон нутгийн төсөвт төвлөрүүлнэ.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэнэ.	-	-	Жил бүр	Автотээврийн төв
13	Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн үеэр татварын улсын байцаагч нарыг ажиллах байраар хангана.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Орлогыг бүрэн төвлөр-үүлнэ.	-	-	Жил бүр	Автотээврийн төв
14	Есөнбулаг сум хариуцан ажиллах татварын улсын байцаагч нарын ажлын ачааллыг харгалзан 4 хүртэлх орон тооны бус хураагчийг "Шинэ-Алтай" худалдааны төв болон томоохон худалдаа үйлчилгээний төвүүдийг хариуцуулан ажиллуулна.	Орлогын төлөвлөгөөний биелэлт	Есөнбулаг сумын төсвийн орлого нэмэгдэж, татвар төлөгчид тогтмол татвар төлдөг болсон байна.	Есөнбулаг сумын төсөв	18.0	2018 оноос	Есөнбулаг сумын Засаг дарга
15	Аймгийн "Шилдэг татвар төлөгч"-ийг шалгаруулан, шагнаж урамшуулна.	-	Жил бүр 3 хүртэлх татвар төлөгчийг шагнаж урамшуулсан байна.	Орон нутгийн төсөв	4.0	Жил бүр	АЗДТГ
16	Дээрхи байгууллагуудтай хамтран ажиллах сонирхлыг бий болгоход чиглэгдсэн эдийн засгийн хөшүүрэг урамшуулал, болзол, уралдааныг зарлан идэвхжүүлнэ.	Төлбөр хураамжийн орлого нэмэгдсэн байх	Төрийн албан хаагчдын ажиллах урам нэмэгдэж ажлын чанар сайжирна.	-	-	2017 оноос	Татварын хэлтэс
17	Мөрдөгдөж буй татварын хууль болон холбогдох дүрэм журамд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхэд санал хүсэлтийг авч нэгтгэн дээд шатны байгууллагад хүргүүлнэ.	Санал хүсэлтийн тоо	Бүх албан байгууллагаас саналыг авч дээд шатны байгууллагуудад хүргүүлсэн байна.	-	-	Жил бүр	СТСХ, Татварын хэлтэс